



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/485

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаад даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020002283



Нийслэлийн Засаг даргын 2018 оны  
05 дугаар сарын 24-ны өдрийн  
А/145-р захиралын хавсралт

"СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРГЭЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго	Үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар түүний нөлөөг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг нийслэлийн хэмжээнд өрнүүлэх.				
Үр нөлөө (Үр нөлөөний шалгуур үзүүлэлт)	Инноваци, зохиогчийн эрхэд тулгуурласан үндэсний соёл, уламжлал, оюуны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нийслэлийн хэмжээнд соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг кластерийн зарчмаар дэмжиж ажиллана. (Нийслэлийн онцлог, боломжид тулгуурласан соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн байдал)				
Үйл ажиллагааны чиглэл	Соёлын олон төрөл, зүйл дотроос мэдлэг, нэмүү өртгийг шингээн инноваци, соёлын боловсрол, зохиогчийн эрхэд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж, нөхцөлийг харгалзан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.				
№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1.	Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнийг брэнд бүтээгдэхүүн болгон нийслэлийн онцлогтой бэлэг дурсгалын зүйлсийг бий болгох	Бэлэг дурсгалын зүйлсийг бий болгосон байдал	НЗДТГ НСУГ Үйлдвэрлэл эрхлэгчид	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2018 оны 7-р сараас  2018 оны 8-р сар
2.	Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнийг брэнд бүтээгдэхүүн болгон нийслэлийн онцлогтой бэлэг дурсгалын зүйлсийг бий болгох	Бэлэг дурсгалын зүйлсийг бий болгосон байдал	НЗДТГ НСУГ Үйлдвэрлэл эрхлэгчид	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2018 оны 7-р сар
3.	Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнийг брэнд бүтээгдэхүүн болгон нийслэлийн онцлогтой бэлэг дурсгалын зүйлсийг бий болгох	Бэлэг дурсгалын зүйлсийг бий болгосон байдал	НЗДТГ НСУГ Үйлдвэрлэл эрхлэгчид	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2018 оны 7-р сар
4.	Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнийг брэнд бүтээгдэхүүн болгон нийслэлийн онцлогтой бэлэг дурсгалын зүйлсийг бий болгох	Бэлэг дурсгалын зүйлсийг бий болгосон байдал	НЗДТГ НСУГ Үйлдвэрлэл эрхлэгчид	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2018 оны 7-р сар